



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/05

Улаанбаатар хот

2026 оны төсвийн хуваарь
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн 36 дугаар жагсаалт, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хууль, Монгол Улсын ерөнхий сайдын 2025 оны 05 дугаар албан даалгаварыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан эрүүл мэндийн байгууллагын төсвийн удирдлагын бүрэн эрхийг хэрэгжүүлэх, төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор эрүүл мэндийн байгууллагуудын 2026 оны төсвийн хуваарийг хавс залтаар баталсугай.
2. Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих зардлын төлбөрийг гүйцэтгэлд үндэслэн холбогдох хууль, тогтоомжийн дагуу санхүүжүүлэхийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (Ц.Батбаатар)-т, төсвийн зарцуулах эрх нээж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газар (Л.Мөнхцэцэг)-т тус тус зөвшөөрсүгэй.
3. Батлагдсан төсвийг зохих журмын дагуу зарцуулж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллахыг Эрүүл мэндийн байгууллагуудын захирал, дарга нарт даалгасугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Ү.Очирбатад үүрэг болгосугай.



Ж.ЧИНБҮРЭН

141251601

